

1. DPUB2 төслийн баг “Номин Холдинг” ХХК-аар зочиллоо

“Номин Холдинг” ХХК нь Монголын топ 8 ААНБ-уудын нэг бөгөөд борлуулалт үйлчилгээ, жижиглэн худалдаа болон бизнесийн бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Нийгмийн хариуцлагаа өндрөөр ухамсарлаж, тасралтгүй манлайлан хөгжиж буй бөгөөд өдгөө 5336 ажилтантай. Монголын тэргүүлэх компани боллоо өргөжиж чаджээ.

Бид “Номин Холдинг” ХХК-ийн хүний нөөцийн албаны дарга Д. Отгонням болон хүний нөөц, бодлогын хэлтсийн хөдөлмөрийн харилцааны менежер Б.Ууганчимэг нартай уулзаж, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэй холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлогын талаар тодрууллаа. “Номин Холдинг” нь 1996 оноос хойш ХБИ-ийг тасралтгүй ажиллуулж байна. Одоогийн байдлаар нийт 87 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагаас 60 нь сонсголын бэрхшээлтэй. Сонсголын бэрхшээлтэй ажилтнуудтайгаа харилцахад харилцааны бэрхшээл тулгардаг ч хамтран ажиллахдаа сэтгэл хангалуун байдаг хэмээн ярьж байлаа.



Д. Отгонням (баруун гар талаас гуравт)
Б. Ууганчимэг (зүүн гар талаас хоёрт)

Мөн харааны бэрхшээлтэй иргэдийн спорт болох “Хонхтой бөмбөгийн холбоо”-г дэмжин ажилладаг бөгөөд багийн гишүүд дунд “Номин Холдинг”-д цахимаар цагийн ажил хийдэг хүмүүс ч байдаг гэнэ. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын хувьд багадаа 5 жил, дээд тал нь 20 жил ажиллаж байгаа бөгөөд эдгээр ажилтнуудын дундаас өнгөрсөн 2021 оны шилдэг ажилтнаар тодорсон хоёр хүн бий.

“Номин Холдинг” ХХК нь 1) Нийгмийн хариуцлага 2) Ажил олголтын квотыг биелүүлэх 3) Ажиллах хүчний нөөц хэмээн үздэг гэсэн 3 шалтгаанаар ХБИ-ийг ажиллуулж байна. Цаашид нягтлан, оффисын ажилтан зэрэг ажлын байруудад аль болох олон ХБИ-ийг ажиллуулах хүсэлтэй буйгаа илэрхийлж байлаа.

2. DPUB2 төслийн баг “АПУ” ХК-аар зочиллоо



Уулзалтын дараа АПУ ХК “Амьдралын мөч бүрийг хамтдаа” гэсэн урианы урд дурсгалын зураг даруулав.

DPUB2 төслийн баг “АПУ” ХК-д зочлон Захиргаа, хүний нөөцийн албаны дарга Г. Гантөгс, байгууллага хариуцсан менежер О. Одгэрэл нартай уулзаж, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаар нээлттэй ярилцлаа. АПУ компани нь өдгөө 2000 гаруй ажилтантай ба үүнээс 400 гаруй нь Улаанбаатар хотод ажилладаг. Одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 27 хүн ажиллаж байна.

Эдгээр хөгжлийн бэрхшээлтэй ажилчдын дийлэнх нь хараа болон сонсголын бэрхшээлтэй бөгөөд захиргаа, туслах, нарийн мэргэжлийн ажил хийж байна. Мөн харааны бэрхшээлтэй хүмүүст туслах хөтчийг ажилтнууд дотроо сурган бэлтгэжээ. АПУ компани нь хүн бүрийн олон талт байдал, тэгш байдлыг хүндэтгэх бодлого баримтлан ажилладаг.

Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Г. Гантөгс байгууллагынхаа ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хариуцан ажилладаг. Тиймээс энэ удаагийн уулзалтын үеэр DPUB2 төслийн зүгээс зохион байгуулж буй “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар” болон төслийн зорилгын талаар мэдээлэлтэй боллоо хэмээн ихэд баяртай байлаа. DPUB2 төслийн зүгээс “Ажлын байрны дадлагажуулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ”-ээр дамжуулан ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “АПУ” ХК-тай хамтран ажиллах хүсэлтэй байна.

СЭДЭВ

- 1 DPUB2 төслийн баг “Номин Холдинг” ХХК-аар зочиллоо
- 2 DPUB2 төслийн баг “АПУ” ХК-аар зочиллоо
- 3 Гурав дахь удаагийн “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар” амжилттай зохион байгууллаа
- 4 ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх хоёр дахь удаагийн давтлага сургалт зохион байгууллаа

DPUB2

Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

3. Гурав дахь удаагийн “Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар” амжилттай зохион байгууллаа

DPUB2 төсөл 6-р сарын 16-17-ны өдрүүдэд “Ажлын байрны дадлагажуулагчийн анхан шатны семинар”-ыг гурав дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Энэ удаагийн семинарт Улаанбаатар хотын хөдөлмөрийн бирж, ААНБ, ТББ-уудын төлөөллөөс оролцлоо.

Семинарын оролцогч ААНБ-уудын төлөөллийн нэг “Юнисервис Солюшн” компанийн сургалт хариуцсан сургагч багш мөн чанарын менежер хэлэхдээ “Манай байгууллага нийт 800 орчим ажилтантай ба үүнээс 3.8% нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ажиллаж байна. Бид хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууддаа зориулан шаардлагатай багаж хэрэгсэл, орчны саадыг арилгах зэргээр дэмжлэг үзүүлдэг. Харин өнөөдрийн семинараар “цаашид системтэй арга барилаар ажиллах ёстой гэдгийг ойлгож авсан чухал сургалт боллоо” хэмээн онцлов.



“Ажлын байрны дадлагажуулагчийн талаарх анхан шатны семинар”-ын гурав дахь удаагийн төгсөлт

Сургалтын хоёр дахь өдөр өмнөх семинарын төгсөгчдийн төлөөлөл ажлын байрны дадлагажуулагчийн үүрэг, голчлон хийдэг ажлыг танилцуулах зорилгоор “ААНБ-уудтай уулзалт хийх”, “Ойлгомжтой заах арга барил” гэсэн сэдвээр хоёр төрлийн дасгал ажлыг удирдан явууллаа.

4. ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцийг бэлтгэх хоёр дахь удаагийн давтлага сургалт зохион байгууллаа

DPUB2 төсөл 6-р сарын 27-ны өдөр Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн их танхимд “ААНБ-уудад зориулсан нөлөөллийн семинарыг зохион байгуулах хүний нөөц (ХБИ)-ийг бэлтгэх” хоёр дахь удаагийн давтлага сургалтыг зохион байгууллаа.

Эхний удаагийн сургалт 5-р сарын сүүлээр зохион байгуулагдаж, япон хэл дээрх материалыг хэрхэн нутагшуулах, ААНБ-уудад нөлөөлөх үйл ажиллагатай холбоотой ерөнхий мэдээллийн талаар санал солилцсон байсан юм.



Тус нөлөөллийн багийн гишүүн Х. Батчимэг бусад оролцогчдоо “Нийгмийн загвар”-ын талаар танилцуулж байна.

Энэ удаа оролцогчид нэмэлт өөрчлөлт оруулсан сургалтын материалынхаа талаар өөр хоорондоо танилцуулав. Үүний дараа Япон улсаас мэргэжилтэн багш нар цахимаар холбогдож, сургалтын материалыг эцэслэн найруулах талаар зөвлөгөө өгсөн юм.

Тус сургалтын үеэр оролцогчид 1) Сургалтын материал боловсруулах 2) Семинар удирдан явуулах багш нарын баг гэсэн хоёр ажлын хэсгийг байгууллаа. Ажлын хэсэг тус бүр 4 хүнтэй бөгөөд 10-р сард зохион байгуулагдах “ААНБ-уудад нөлөөлөх семинар”-ын сургалтын материал, сургагч багш нарыг чадавхжуулах тал дээр санал нэгдэв.



dpub.jica@gmail.com



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5 Улаанбаатар-15160



<https://www.facebook.com/jicadpub1and2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

